



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, залуучуудын теартын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/273/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер:С.Нацагдорж Утас:261685 Цахим хаяг:natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Аудитор:Б.Батхишиг Утас:263533 Цахим хаяг:batkhisigb@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал:П.Шаравхорол Утас:88472789 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТЕАТРЫН
АРГА Н.АРИУНБОЛД ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 07/384
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, залуучуудын театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 40,750.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай нийцээгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 158 дугаар тогтоолоор Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтад орсон 850 хүний суудалтай театрын шинэ барилгыг улсын комисс ашиглалтад хүлээн авч, Хүүхэд, залуучуудын театрт хүлээлгэн өгсөн байна.

Тус театрын нээлтийн арга хэмжээг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Нийслэлийн соёл урлагийн газар, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын

газартай хамтран 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, нээлтийн үйл ажиллагаанд 110,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 322,399.4 мянган төгрөг, байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 287,031.1 мянган төгрөг, нийт 609,430.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 558,843.5 мянган төгрөгийг зарцуулж, нийт 50,587.0 мянган төгрөгийг төвлөрүүлснээс 50,387.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Бусад асуудал

Тайлант онд хүүхэд, залуучуудад зориулсан 3 уран бүтээлийг нийт 83 удаа тоглож, 35,950 гаруй үзэгчдэд толиулсан байна. Мөн хүүхдийн соёлын боловсролыг дэмжих, үндэсний дархлаа, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Бичгийн өв бидний соёл” үзэсгэлэн гаргасныг 4,200 хүүхэд үзэж сонирхсон байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	618,654,423.00	639,950,267.86
33	АВЛАГА	1,395,000.00	53,190,159.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,803,159.36
33101	Цалингийн авлага	-	2,326,147.78
33103	ХАОАТ-ын авлага	-	477,011.58
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,395,000.00	50,387,000.00
34	УРЬДЧИЛГАА	441,530,000.00	6,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	441,530,000.00	6,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	175,729,423.00	580,760,108.50
35100	Түүхий эд материал	-	72,000.00
35130	Эм боох материал	-	72,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	88,888,500.00	47,135,900.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	101,758,040.00
35400	Хангамжийн материал	86,840,923.00	431,794,168.50
35410	Бичиг хэргийн материал	3,884,280.00	5,797,440.00
35420	Аж ахуйн материал	23,073,480.00	53,170,831.50
35430	Сэлбэг хэрэгсэл	-	141,450.00
35450	Барилгын засварын материал	-	82,947,000.00
35470	Бусад хангамжийн материал	59,883,163.00	289,737,447.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	994,667,034.22	5,014,707,342.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	994,667,034.22	5,014,707,342.72
392	Биет хөрөнгө	994,667,034.22	5,014,707,342.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	28,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	-	(777,777.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	119,120,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(1,500,000.00)	(8,155,000.01)
39205	Машин тоног төхөөрөмж	536,192,635.00	3,894,016,895.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(58,557,088.89)	(299,799,077.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	555,154,152.50	1,449,243,752.50
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(66,622,664.39)	(179,941,449.04)
39217	Номын фонд	-	13,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,613,321,457.22	5,654,657,610.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	50,856,887.78
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	50,856,887.78
41300	Өглөг	-	50,856,887.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	466,887.78
41312	НДШ-ийн өглөг	-	466,887.78
41360	Бусад өглөг	-	50,390,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	3,000.00
41366	Дансны өр	-	50,387,000.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,613,321,457.22	5,603,800,722.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,613,321,457.22	5,603,800,722.80
51200	Хуримтлагдсан үр дүн	1,613,321,457.22	5,603,800,722.80
51210	Өмнөх үеийн үр дүн	886,954,396.98	1,613,321,457.22
51220	Тайлант үеийн үр дүн	726,367,060.24	3,990,479,265.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,613,321,457.22	5,654,657,610.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	2,195,082,301.00	7,684,971,899.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,950,201.00	4,653,088,420.00
1200	Нийтлэг татварын бус орлого	175,950,201.00	4,653,088,420.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	281,388,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	204,988,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	76,400,000.00
120005	Түрээсийн орлого	-	28,125,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	174,914,001.00	4,039,269,960.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	1,036,200.00	304,304,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,019,132,100.00	3,031,883,479.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,077,375,100.00	2,709,484,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,077,375,100.00	2,709,484,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	941,757,000.00	322,399,379.99
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	940,362,000.00	322,399,379.99
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,395,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (2)	1,468,715,240.77	3,694,492,634.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,468,715,240.77	3,694,492,634.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,126,496,631.05	3,266,598,786.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	610,485,055.55	1,660,458,311.61
210101	Үндсэн цалин	439,843,169.87	1,181,929,256.89
210102	Нэмэгдэл	56,567,444.50	193,056,990.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,260,000.00	177,740,000.00
210104	Урамшуулал	2,616,010.00	107,732,064.40
210105	Гэрээт ажлын цалин	32,198,431.18	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	76,566,884.92	209,470,839.15
210201	Тэтгэврийн даатгал	52,143,990.07	141,658,573.97
210202	Тэтгэмжийн даатгал	6,134,587.15	16,645,894.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,898,869.89	9,976,880.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,210,246.62	8,237,897.90
210205	Эрүүл мэндийн даатгал	12,179,191.19	32,951,592.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,476,903.00	66,479,409.81
210301	Гэрэл, цахилгаан	-	34,426,236.72
210302	Түлш, халаалт	2,556,903.00	15,153,291.51
210303	Цэвэр, бохир ус	-	5,219,881.58
210304	Байрны түрээс	33,920,000.00	11,680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,679,093.00	84,231,775.30
210401	Бичиг хэрэг	2,344,450.00	4,352,401.53
210402	Тээвэр, шатахууны зардал	12,556,250.00	14,215,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,620,000.00	2,399,705.27
210404	Ном, хэвлэл	2,401,035.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,757,358.00	48,328,778.50

210408	Бараа материал актласны зардал	-	14,935,590.00
2105	Нормативт зардал	-	427,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	427,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	275,000.00	31,438,000.00
210604	Урсгал засвар	275,000.00	31,438,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,012,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,012,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,696,720.00	750,856,184.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	242,883,620.00	747,447,664.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	421,020.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	624,000.00	440,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	47,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,304,974.58	463,237,115.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,188,750.00	101,243,564.47
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,744,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	126,372,224.58	361,993,551.50
212	ТАТААС	-	11,250,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	11,250,000.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	11,250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	342,218,609.72	416,643,848.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,231,700.00	131,500,000.00
213202	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,231,700.00	131,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	323,986,909.72	285,143,848.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	292,010,892.72	234,556,811.06
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	31,976,017.00	50,587,037.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	726,367,060.23	3,990,479,265.58
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(4)	726,367,060.23	3,990,479,265.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,019,132,100.00	3,318,914,579.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	287,031,100.00
1200	Нийтлэг татварын бус орлого	-	287,031,100.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	258,906,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	182,506,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	76,400,000.00
120005	Бусад нийтлэг бус татварын орлого	-	28,125,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,019,132,100.00	3,031,883,479.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,077,375,100.00	2,709,484,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,077,375,100.00	2,709,484,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	941,757,000.00	322,399,379.99
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	940,362,000.00	322,399,379.99
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,395,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,019,132,100.00	3,054,601,679.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,019,132,100.00	3,054,601,679.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,675,518,490.29	2,637,957,831.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	610,815,903.83	1,658,768,685.12
210101	Үндсэн цалин	446,272,867.98	1,187,718,414.65
210102	Нэмэгдэл	56,276,789.98	191,927,007.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,094,539.06	177,133,597.06
210104	Урамшуулал	2,616,010.00	101,989,665.76
210105	Гэрээт ажлын хөлс	26,555,696.81	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,538,062.46	213,496,737.22
210201	Тэтгэврийн даатгал	52,115,167.61	145,528,752.04
210202	Тэтгэмжийн даатгал	6,134,587.15	16,682,124.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,898,869.89	9,956,930.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,210,246.62	8,297,677.90
210205	Эрүүл мэндийн даатгал	12,179,191.19	33,031,252.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,476,903.00	66,479,409.81
210301	Гэрэл, цахилгаан	-	34,426,236.72
210302	Түлш, халаалт	2,556,903.00	15,153,291.51
210303	Цэвэр, бохир ус	-	5,219,881.58
210304	Байрны түрээс	33,920,000.00	11,680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	320,674,460.00	104,096,565.27
210401	Бичиг хэрэг	9,248,230.00	4,143,440.00
210402	Тээвэр, шатахуун	12,556,250.00	13,455,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,620,000.00	2,399,705.27

210404	Ном, хэвлэл	1,873,750.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	295,376,230.00	84,098,120.00
2105	Нормативт зардал	12,861,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,861,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,080,160.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,942,160.00	-
210602	Тавилга	5,863,000.00	-
210604	Урсгал засвар	275,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,012,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,012,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	532,402,220.00	580,287,884.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,589,120.00	575,781,864.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	421,020.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	624,000.00	440,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	1,145,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,657,781.00	14,828,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,913,781.00	14,828,550.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,744,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	343,613,609.71	416,643,848.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,231,700.00	131,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,231,700.00	131,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	325,381,909.71	285,143,848.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	292,010,892.71	234,556,811.06
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	33,371,017.00	50,587,037.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	264,312,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (5)	-	253,062,900.00
22	Хөрөнгийн зардал	-	253,062,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	253,062,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	253,062,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(253,062,900.00)
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	11,250,000.00
25	Гадаад валютын ханшийн зөрүү	-	11,250,000.00
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	11,250,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (7)	-	(11,250,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(4)	-	-
14	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	886,954,396.98	886,954,396.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	886,954,396.98	886,954,396.98
Тайлант үеийн үр дүн	-	-	726,367,060.24	726,367,060.24
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,613,321,457.22	1,613,321,457.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,613,321,457.22	1,613,321,457.22
Тайлант үеийн үр дүн	-	-	3,990,479,265.58	3,990,479,265.58
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	5,603,800,722.80	5,603,800,722.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,710,975,000.00	2,474,927,288.94	236,047,711.06	91.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,710,975,000.00	2,474,927,288.94	236,047,711.06	91.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,693,089,700.00	2,463,427,288.94	229,662,411.06	91.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,784,638,000.00	1,658,768,685.12	125,869,314.88	92.9
Үндсэн цалин	1,187,719,100.00	1,187,718,414.65	685.35	100.0
Нэмэгдэл	189,033,200.00	191,927,007.65	(2,893,807.65)	101.5
Унаа хоолны хөнгөлөлт	244,000,000.00	177,133,597.06	66,866,402.94	72.6
Урамшуулал	163,885,700.00	101,989,665.76	61,896,034.24	62.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,329,800.00	213,496,737.22	15,833,062.78	93.1
Тэтгэврийн даатгал	155,944,200.00	145,528,752.04	10,415,447.96	93.3
Тэтгэмжийн даатгал	18,346,400.00	16,682,124.51	1,664,275.49	90.9
ҮОМШӨ-ний даатгал	9,173,200.00	9,956,930.77	(783,730.77)	108.5
Ажилгүйдлийн даатгал	9,173,200.00	8,297,677.90	875,522.10	90.5
Эрүүл мэндийн даатгал	36,692,800.00	33,031,252.00	3,661,548.00	90.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,185,900.00	52,052,409.81	83,133,490.19	38.5
Гэрэл, цахилгаан	20,000,000.00	19,999,236.72	763.28	100.0
Түлш, халаалт	88,320,000.00	15,153,291.51	73,166,708.49	17.2
Цэвэр, бохир ус	15,185,900.00	5,219,881.58	9,966,018.42	34.4
Байрны түрээс	11,680,000.00	11,680,000.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	102,147,600.00	101,865,565.27	282,034.73	99.7
Бичиг хэрэг	4,197,600.00	4,143,440.00	54,160.00	98.7
Тээвэр, шатахуун	13,600,000.00	13,455,300.00	144,700.00	98.9
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,400,000.00	2,399,705.27	294.73	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	81,950,000.00	81,867,120.00	82,880.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	177,000,000.00	175,479,900.00	1,520,100.00	99.1
Багаж, техник хэрэгсэл	147,000,000.00	146,878,900.00	121,100.00	99.9
Тавилга	30,000,000.00	28,601,000.00	1,399,000.00	95.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	249,488,400.00	246,935,441.52	2,719,558.48	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	242,500,000.00	242,429,421.52	237,178.48	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	488,400.00	421,020.00	67,380.00	86.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	440,000.00	1,560,000.00	22.0
Улсын мэдээллийн маягт бэлтгэх, хэвлэх	2,000,000.00	1,145,000.00	855,000.00	57.3

Бараа үйлчилгээний бусад зардал	15,300,000.00	14,828,550.00	471,450.00	96.9
Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,828,550.00	171,450.00	98.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	-	300,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,885,300.00	11,500,000.00	6,385,300.00	64.3
Бусад урсгал шилжүүлэг	17,885,300.00	11,500,000.00	6,385,300.00	64.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,885,300.00	11,500,000.00	6,384,800.00	64.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,710,975,000.00	2,474,927,288.94	236,047,711.06	91.3
Улсын төсвөөс санхүүжих	2,710,975,000.00	2,474,927,288.94	236,047,711.06	91.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
Төсвийн байгууллага	1	1	-	100
АЖИЛЛАГСДЫН ТОО	110	110	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	87	87	-	100
Үйлчлэх ажилтан	22	22	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	-	609,430,479.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	598,180,479.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	427,593,442.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	14,427,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	14,427,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	77,583,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	77,583,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	333,183,442.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	333,183,442.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		170,587,037.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	120,000,000.00
213202	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	120,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	50,587,037.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	50,587,037.19
25	Гадаад валютын ханшийн зөрүү	-	11,250,000.00
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	11,250,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	-	609,430,479.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	287,031,100.00
1200	Нийтлэг татварын бус орлого	-	287,031,100.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	258,906,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	182,506,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	76,400,000.00
120005	Түрээсийн орлого	-	28,125,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	322,399,379.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	322,399,379.99
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	322,399,379.99
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
11000	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 15,185.0 мянган төгрөгийн 3 алдаа² илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгө дансны авто тээврийн хэрэгслийн ангилалд хувцас хатаагч 10,650.0 мянган төгрөгөөр бүртгэсэн	1	10,650.0	-	-	1	10,650.0	1	10,650.0	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн орлогыг 3,500.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	3,500.0	-	-	1	3,500.0	1	3,500.0	-	-	-	-
Санхүүгийн үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогыг ангилал зөрүүлж бүртгэсэн	1	1,035.0	-	-	1	1,035.0	1	1,035.0	-	-	-	-
Нийт дүн	3	15,185.0	-	-	3	15,185.0	3	15,185.0	-	-	-	-

3.2 Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 40,750.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 36,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг хүргүүлж, 4,750.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Тоо	Дүн	Тоо	Дүн
			Тоо	Дүн				
Тус театр нь 2024 онд театрын барилгыг хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байгаа ч барилга, байгууламжийг үндсэн хөрөнгөд бүртгэж, санхүүгийн тайланд тусгаагүй.	1	-	-	-	-	-	1	-
Тайлант онд 4,750.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээ бусдаар	1	4,750.0	-	-	-	-	1	4,750.0

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ч гэрээг дүгнээгүй байна.								
Соёлын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар өгүүлэл, ярилцлага мэдээ бэлтгэх гэсэн нэг утга, зорилгоор 4 аж ахуйн нэгж байгууллагатай тус бүр 9,000.0 мянган төгрөг, нийт 36,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан нь хуульд заасан харьцуулалтын арга хэрэглээгүй байна.	1	36,000.0	-	-	1	36,000.0	-	-
Дүн	2	40,750.0	-	-	1	36,000.0	2	4,750.0

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 159 мэдээллийн мэдээлэхээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 орлогын 15,022.5 мянган төгрөг, зарлагын нийт 7 гүйлгээний 396,936.9 мянган төгрөг, нийт 411,959.4 мянган төгрөгийг ил тод мэдээлээгүй байна.	1	411,959.4	1	411,959.4	-	-
Дүн	1	411,959.4	1	411,959.4	-	-